



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-4-12 № 04/106

Зөрчил арилгуулах тухай

Эрдэнэт Булганы цахилгаан түгээх станц ТӨХК-ний 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

2012 оны ээлжийн амралтыг илүү тооцож нийт 2,1 сая төгрөг илүү олгосон. Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4-дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт "Санхүүгийн тайлан нь үнэн зөв, тоо баримт материал, бодит тоо мэдээнд үндэслэх", Нийгмийн Хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 тоот тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын заалтыг

Ой тэмдэглэхэд нь зориулж Цахилгаан Дамжуулах Сүлжээ ТӨХК, Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний төвд тус бүр 0,8 мянган төгрөг бүгд 1,6 сая төгрөгийн хандив, Монголын Эрчим Хүчний Инженерүүдийн Холбоо ТББ-д 1,5 сая төгрөгийн гишүүний татвар нийт 3,1 сая төгрөг олгосон, 2012 онд 4 хүнд 29,0 мянган төгрөгийн зээл олгож, 20,8 сая төгрөгийн тооцоо хийгээгүй, Б.Наранбаатарт банкнаас цалингийн зээл авахад нь компаниас баталгаа гаргаж, банк үл маргах журмаар 3,8 сая төгрөгийн зээлийн өрийг компаний хөрөнгөнөөс төлүүлсэн. Энэ нь ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 3 дахь заалт "...төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэхийг хориглоно..." заалтыг

СЭЗХ-ийн дарга ерөнхий нягтлан бодогч Л.Пүрэвдоржийн Англи улсад эмчилгээ хийлгэх зардалд 54,6 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүн Э.Дуламсүрэнд БНСУ-д эмчилгээ хийлгэх зардалд 11,0 сая төгрөг нийт 65,6 сая төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 5 дахь заалт "Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчид тусламж нөхцөл журам"-ын ...б/ ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр (нөхөр)-ийн

ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СТАНЦ ТӨХК-НИЙ ТУЗ-ИЙН
ДАРГА Ж.ТӨМӨРБААТАР

070254

төрсөн нутагт явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд ирэх, очих замын зардлыг автомашин, төмөр замын тээврийн тухайн үед мөрдөж байгаа энгийн үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно, ТБОНӨТхуулийн 21 дүгээр зүйлийн 12 “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн .

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын”-ын 3.1.1-д”...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж байх, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч дээрх зөрчлийг арилгах албан шаардлага өгч байна.

Дээрх аудитын явцад илэрсэн нийт 94,4 сая төгрөгийн зөрчлийг арилгаж цаашид гаргахүй байхын тулд ажлаа зохион байгуулж, биелэлтийг гарган 2013 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний Аудитын Газарт хариу ирүүлэхийг ЭБЦТС ТӨХК-ний захирал Ч.Баттутяа, ерөнхий нягтлан бодогч М.Энхтуяа нарт хариуцуулав



Аудитор

Ш.Отгонбаяр